

**ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

2024 оны 12 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
<p align="center">Стратегийн зорилго 1. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог сайжруулна. (Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2.7.3), (Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 2.7.3), (Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 4.3.9), (Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө 2.5.2, 2.7.5), (Гадаадын иргэн, харьяатын газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний 3,4,5,6 дугаар зорилт)</p>							
<p align="center">Зорилт 1. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ.</p>							
1	Монгол Улсын хууль тогтоомжид санал хүргүүлэх, байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаанд хамаарах эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох	Урсгал зардал	Санал хүргүүлсэн хууль тогтоомж, боловсруулж баталсан эрх зүйн баримт бичгийн тоо	11/6	5/5	Улсын Их Хурлаас батлах 5 хуулийн төсөлд тус тус санал боловсруулан хүргүүлж, байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаанд хамаарах 1 журамд нэмэлт, өөрчлөлт оруулж, 1 журам шинээр баталлаа. Үүнд: Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Харьяатын тухай хууль, Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд оруулах санал боловсруулж 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/339, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд оруулах саналаа 05 дугаар сарын 21-ний өдрийн 01/1067 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээ. Мөн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн үзэл баримтлал, танилцуулгыг сайжруулан ХЗДХЯ-ны ХЗБГ-ын шинжээч Б.Алтантуяад altantuab@mojha.gov.mn хаягаар 02 дугаар сарын 29-ний өдөр хүргүүлээ. Мөн санал авахаар ирүүлсэн 5 албан бичгийн хариу хүргүүлсэн. Үүнд: 1. ХЗДХЯ-ны 05 дугаар сарын 31-ний өдрийн 9/2826 дугаар албан бичгээр "Салбарын статистик мэдээллийн	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журам"-д холбогдох санал</p> <p>2. ХЗДХЯ-ны 06 дугаар сарын 07-ны өдрийн 4/2976 дугаар албан бичгээр Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 231 дүгээр тогтоолоор баталсан "Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны (2023-2027) төлөвлөгөө"-нд холбогдох санал</p> <p>3. ГХЯ-аас 09 дүгээр сарын 02-ны өдрийн 07/4161 дугаар албан бичигт Байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд салбарын чиглэлээр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн талаарх холбогдох санал</p> <p>4. ХЗДХЯ- 09 дүгээр сарын 03-ны өдрийн 3/597 дугаар албан бичгээр Үндсэн чиглэлийн хуулийн төсөлд холбогдох санал</p> <p>5. ХЗДХЯ-ны 2024.09.25-ны өдрийн ХЭГ/1807 тоот албан бичгээр "Засгийн газрын хуралдааны цахим систем" ашиглан цахимаар хүргүүлэхтэй холбогдуулан хууль тогтоомж хариуцсан хуулийн мэргэжилтэний мэдээллийг хүргүүлсэн болно.</p> <p>Байгууллагын даргын 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/159 дүгээр тушаалаар "Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчид албан тушаалын цол олгох, хэрэглэх, хураах журам", 06 дугаар сарын 20-ны өдрийн А/241 дүгээр тушаалаар "Гадаадын иргэн, харьяатын газрын төрийн тусгай албан хаагчид мэргэшлийн зэрэг тогтоох шалгуур үзүүлэлт, түүнийг олгох журам", 10 дугаар сарын 01-ний өдрийн А/406 дугаар тушаалаар "Гадаадын иргэн, харьяатын газрын төрийн тусгай албан хаагчид хилийн боомт, орон нутагт ажилласан хугацааны мөнгөн урамшуулал олгох журам", мөн өдрийн А/407 дугаар тушаалаар "Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчийг зайнаас ажиллуулах журам", 10 дугаар сарын 31-ний өдрийн А/454 дүгээр тушаалаар "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг тус тус шинээр болон шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөж байна.</p>	

1	2	3	4	5	6	7	8
2	Хууль тогтоомжийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах	Урсгал зардал	Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	<p>Байгууллагын дотоод сүлжээний "Хуулийн сан"-д холбогдох өөрчлөлтийг тухай бүр оруулан ажиллаж байна.</p> <p>-Араб, Мальдив улстай байгуулсан Засгийн газар хоорондын хэлэлцээр;</p> <p>-Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн "Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам", "Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цолны, мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам, нэмэгдлийн хэмжээ"-г тогтоох тухай 160 дугаар тогтоол;</p> <p>-“Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/141 дугаар тушаал;</p> <p>-Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн “Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчид албан тушаалын цол олгох, хэрэглэх, хураах журам” батлах тухай А/159 дугаар тушаал;</p> <p>- “Нэгжийн индексийг шинэчлэн батлах тухай” А/161 дүгээр тушаал;</p> <p>-“Даргын дэргэдэх зөвлөлийн ажиллах журамд өөрчлөлт оруулах тухай” А/237 дугаар тушаал;</p> <p>-“Гадаадын иргэнийг Монгол улсаас албадан гаргах шийдвэрийг хэрэгжүүлэх журам” батлах тухай А/243 дугаар тушаал;</p> <p>-ХЗДХЯ-ны сайдын А/129 дугаар тушаалаар баталсан “ГИХГ-ын үйл ажиллагааны стратери,зохион байгуулалтын өөрчлөлтийн хөтөлбөр,зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай”;</p> <p>-ГИХГ-ын даргын А/241 дугаар тушаалаар баталсан “Төрийн тусгай албан хаагчдад мэргэшлийн зэрэг, нэмэгдэл олгох тухай”;</p> <p>-ГИХГ-ын даргын А/455 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнахад баримтлах заавар”;</p> <p>-ГИХГ-ын даргын 2024 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн</p>	90

1	2	3	4	5	6	7	8
						<p>A/454 дугаар тушаалаар баталсан шинэчлэн найруулсан "Хөдөлмөрийн дотоод журам";</p> <p>"Гадаадын иргэн, харьяатын газрын төрийн тусгай албан хаагчид мэргэшлийн зэрэг тогтоох шалгуур үзүүлэлт, түүнийг олгох журам" батлах тухай A/241 дугаар тушаалуудыг тус тус хуулийн санд байршуулсан.</p>	
3	<p>Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах</p> <p>тогтоомж, баримт тогтоол нэгтгэн</p>	Урсгал зардал	Хэрэгжилтийн хувь	100	100	<p>Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны 01-10 дугаар сарын тайланг боловсруулан албан бичгээр болог цахим хаягаар тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв. Түүнчлэн хууль тогтоомжийн 2024 оны хагас жилийн тайланг 06 дугаар сарын 04-ний өдөр, жилийн эцсийн тайланг 11 дүгээр сарын 27-ны өдөр боловсруулж, үнэлгээ хийлгэхээр Хяналт-шинжилгээ үнэлгээ, аудитын хэлтэст, тайлагнахаа, цахим хаягаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.</p> <p>Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийг 2001-2023 оноор боловсруулж, 01 дүгээр сарын 22-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахим хаягаар болон байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэст тус тус хүргүүлэв.</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05, 2024 оны 73 дугаар зарлигаар батлагдсан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам"-ын дагуу холбогдох хэсгийн 2024 оны улирлын танилцуулах мэдээг 03 дугаар сарын 28, 06 дугаар сарын 12, 09 дүгээр сарын 26-ны өдрийн 01/659, 01/1224, 01/1910 дугаар албан бичгээр болон хаягаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.</p> <p>Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны 2024 оны 24/03 дугаар тогтоолын тайланг 08 дугаар сарын 23-ны өдрийн 02/1678 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 100 хоногийн үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдаагүйтэй холбогдуулан Ерөнхий сайдын 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтээр тайланг ирүүлнэ гэсэн тул нэгтгэн боловсруулж, 11 дүгээр</p>	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>сарын 05-ны өдрийн 01/2190 дүгээр албан бичгээр болон цахим хаягаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журам болон энэ төлөвлөгөөний дагуу 2024 онд хууль тогтоомжийн холбогдох хугацааны тайланг бүрэн тайлагнаж ажиллав. Мөн хууль тогтоомжид хамаарах бусад баримт бичгийн 6 тайланг боловсруулан тухай бүр хугацаанд нь Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн байна.</p> <p>Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хагас жилийн тайланг 06 дугаар сарын 04-ний өдөр, тоон утгад нэмэлт оруулсан тайланг 08 дугаар сарын 26-ны өдөр, жилийн эцсийн тайланг 11 дүгээр сарын 27-ны өдөр үнэлгээ хийлгэхээр тус тус Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэст, тайлагнахаар цахим хаягаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны тайланг боловсруулж, үнэлгээ хийлгэхээр мөн 11 дүгээр сарын 27-ны өдөр Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс болон цахим хаягаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.</p> <p>"Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 01-10 дугаар сарын тайланг боловсруулан албан бичгээр болон цахим хаягаар тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хагас жилийн тайланг 06 дугаар сарын 04-ний өдөр, жилийн эцсийн тайланг 11 дүгээр сарын 27-ны өдөр боловсруулж, тус тус Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс болон цахим хаягаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээ.</p> <p>"Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр"-ийн 2023 оны тайланг 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01/91 дүгээр албан бичгээр болон цахим хэлбэрээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p>	

1	2	3	4	5	6	7	8
						<p>"Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр"-ийн биелэлтийг 03 дугаар сарын 28-ны өдрийн 01/657 дугаар албан бичгээр болон хаягаар Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэв.</p> <p>"НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө"-ний Наймдугаар хэсэгт тусгагдсан "Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах" чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 07 дугаар сарын 30-ны өдрийн 01/1534 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөө (2023-2027)"-ийн хэрэгжилтийг боловсруулж, 11 дүгээр сарын 12-ны өдрийн 01/2240 дүгээр албан бичгээр болон цахим хаягаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.</p> <p>"Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн 2024-2027 оны үйл ажиллагааны Үндэсний 5 дугаар төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг 11 дүгээр сарын 18-ны өдрийн 01/2286 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журам болон энэ төлөвлөгөөний дагуу 2024 оны тайланг холбогдох газруудад хүргүүлж, бүрэн тайлагнасан. Түүнчлэн бодлогын баримт бичигт хамаарах бусад хөтөлбөрийн 5 тайланг боловсруулан тухай бүр хугацаанд нь холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлсэн байна.</p>	
4	Хууль зүй, дотоод хэргийн сайдын шуурхай үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах	Урсгал зардал	Гүйцэтгэлийн хувь	100	100	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн болон 05 дугаар сарын 15-ны өдрийн шуурхай хуралдаанд танилцуулах мэдээллийг бэлтгэн тухай бүр тус тус байгууллагын даргад биечлэн танилцуулж, 01 дүгээр сарын 23-ны өдрийн шуурхай хуралдаанаас ирүүлсэн үүргийн биелэлтийг хангуулан тайланг 02 дугаар сарын 20-ны өдрийн 01/378 дугаар	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн сайдын шуурхай хуралдааны үүргийг тус яамнаас дахин ирүүлээгүй болно.</p> <p>Монгол Улсын Ерөнхий сайд хилийн чанад дахь иргэдтэй хийсэн цахим уулзалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний санал болон дараагийн уулзалтад иргэдийн зүгээс хөндөж болзошгүй асуудалд туссан ажлын биелэлтийг 04 дүгээр сарын 11-ний өдрийн 02/761 дүгээр албан бичгээр Гадаад харилцааны яаманд хүргүүллээ.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн "Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, дэг журмыг сайжруулах тухай" 1/5 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг 09 дүгээр сарын 26-ны өдрийн 01/1908 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлэв.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, 11 дүгээр сарын 07-ны өдөр байгууллагын даргаар батлуулан egr.e-mongolia.mn системд нийтэлсэн.</p> <p>Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөлд тусгах арга хэмжээний саналыг нэгтгэн боловсруулж, 04 дүгээр сарын 01-ний өдрийн 01/673 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайд хүргүүлэв.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоогийн Сүхбаатар аймагт хийх айлчлалтай холбогдуулан байгууллагын үйл ажиллагааны 2020-2024 оны тайланг холбогдох чиглэлийн дагуу хураангуйлж боловсруулан Зүүн бүс дэх газраас Сүхбаатар аймаг дахь үйл ажиллагааны мэдээллийг нэгтгэж, товч танилцуулгыг 04 дүгээр сарын 26-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд цахим хаягаар хүргүүлсэн.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн сайдаас Засгийн газрын хуралдаанд мэдээлэл хийхтэй холбогдуулан байгууллагын сүүлийн 5 жилд хэрэгжүүлсэн онцлох үйл ажиллагааны мэдээллийг боловсруулж, 05 дугаар сарын 07-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд</p>	

1	2	3	4	5	6	7	8
						<p>Цахим хаягаар хүргүүлээ.</p> <p>Хүний эрхийн үндэсний комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс Хууль зүй, дотоод хэргийн сайдад ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд 09 дүгээр сарын 11-ний өдөр Цахим хаягаар хүргүүлсэн.</p> <p>Тайлант хугацаанд Хууль зүй, дотоод хэргийн сайдын шуурхай үүргийн хүрээнд болон эрх барих, гүйцэтгэх дээд шатны байгууллагаас сайдад хандаж ирүүлсэн саналын төсөл, тайлан, мэдээг бэлтгэн хугацаанд нь хүргүүлж, тухай бүр биелэлтийг бүрэн хангаж ажиллав.</p>	
5	"Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний төсөлд санал хүргүүлэх	Урсгал зардал	Санал хүргүүлсэн эсэх	1	1	<p>Байгууллагын даргын 12 дугаар сарын 15-ны өдрийн А/468 дугаар тушаалаар байгуулсан "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний төсөлд санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж, төлөвлөгөөний төсөлд зохион байгуулалтын нэгжээс ирүүлсэн саналуудыг ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох журмын дагуу нэгтгэв. "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний төсөлд саналыг боловсруулан 01 дүгээр сарын 02-ны өдрийн 01/06 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаярт хүргүүлсэн. (1 дүгээр улиралд төлөвлөж хугацаандаа бүрэн хэрэгжүүлсэн)</p> <p>Дээрх төслийг эрэмбэлэх зорилгоор Эдийн засаг, хөгжлийн яаманд 01 дүгээр сарын 31-ний өдөр зохион байгуулагдсан хэлэлцүүлэгт Мэдээллийн технологийн хэлтсийн даргын хамт оролцож, хүргүүлсэн саналын хүрээнд тайлбар, танилцуулга хийлээ.</p> <p>Түүнчлэн жилийн үйл ажиллагаанд төлөвлөгдөөгүй боловч дээд шатны байгууллагаас цаг үеийн шинжтэй үүрэг болгосон бодлогын баримт бичигт холбогдох хөтөлбөр, төлөвлөгөөний саналыг тухай бүр боловсруулж хүргүүлсэн.</p> <p>"Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөлд хүргүүлэх санал боловсруулж, 08 дугаар сарын 06-ны өдрийн 01/1595 дугаар албан бичгээр, нэмэлт тайлбарыг 08 дугаар сарын 19-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайдад тус тус хүргүүлсэн.</p>	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний төсөлд тусгах саналыг холбогдох нэгжүүдээс нэгтгэн боловсруулж, 09 дүгээр сарын 27-ны өдрийн 01/1920 дугаар албан бичгээр болон цахим хаягаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.</p> <p>Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөл боловсруулах “Ажлын хэсэг байгуулах тухай” А/524 дүгээр тушаалын төслийг боловсруулж, 11 дүгээр сарын 29-ний өдөр батлууллаа.</p>	
6	Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулж, тайлагнах	Урсгал зардал	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	98.4	100	<p>Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах саналыг зохион байгуулалтын нэгжүүдээс ирүүлснийг нэгтгэн боловсруулж, 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулан хэлэлцүүлсэн. Төлөвлөгөөний төслийг 12 дугаар сарын 26-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж баталгаажуулсан.</p> <p>Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлагдсантай холбогдуулан 16 зохион байгуулалтын нэгжийн төлөвлөгөөг хүлээн авч, засвар, өөрчлөлт хийн 01 дүгээр сарын 08-ны өдөр байгууллагын даргаар батлуулж, нэгж бүрд хүлээлгэн өгөв.</p> <p>Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийг 05 дугаар сарын 31-ний өдрөөр эцэслэн зохион байгуулалтын нэгжүүдээс хүлээн авч, нэгтгэн боловсруулж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэст 06 дугаар сарын 04-ний өдөр хүргүүлсэн.</p> <p>Жилийн эцсийн хэрэгжилтийг 11 дүгээр сарын 19-ний өдрөөр эцэслэн нэгтгэн боловсруулж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэст 11 дүгээр сарын 29-ний өдөр хүргүүлсэн ба төлөвлөгөөний хэрэгжилт 95.9 хувиар дүгнэгдлээ.</p> <p>Түүнчлэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт болон байгууллагын үйл ажиллагааны 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг тус тус нэгтгэн боловсруулж, нэгжийн даргаар хянуулан 11 дүгээр сарын 27-ны өдөр ХШҮАХ-г хүргүүллээ.</p>	90

1	2	3	4	5	6	7	8
						Салбарын стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 96.6, байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 93.9 хувиар тус тус үнэлэгдсэн байна.	
7	Байгууллагын үйл ажиллагааны сар бүрийн төлөвлөгөө батлуулж, тайлагнах	Урсгал зардал	Батлуулсан төлөвлөгөө, тайлангийн тоо	12/12	12/12	Байгууллагын үйл ажиллагааны 01-12 дугаар сарын төлөвлөгөөнд тусгах саналыг зохион байгуулалтын нэгжүүдээс авч нэгтгэн боловсруулж, төлөвлөгөөг дотоод журамд заасан хугацаанд буюу сар бүрийн 01-ний өдрийн дотор байгууллагын даргаар батлуулан Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем (ERP)-ээр нийт албан хаагчдад танилцуулж ажиллалаа. Түүнчлэн үйл ажиллагааны 2023 оны 12 дугаар сар, 2024 оны 01-11 дүгээр сарын тайланг нэгтгэн боловсруулж, дотоод журамд заасан хугацаанд буюу сар бүрийн 05-ны өдрийн дотор Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэст үнэлгээнд хүргүүлж ажиллав. Гүйцэтгэл дутуу, хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар хариуцсан нэгжийн дарга, холбогдох мэргэжилтнүүдэд тухай бүр мэдэгдэж ажилласан болно.	100
8	Боомт, орон нутаг дахь нэгжид цаг үеийн холбогдолтой мэдээ, мэдээлэл, чиглэл хүргүүлэх	Урсгал зардал	Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	Боомт, орон нутаг дахь нэгжийн сарын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг хүлээн авч, ERP программд үүсгэсэн цахим санд хадгалсан. Гадаад харилцааны яаманд хилийн зарим боомтын цагийн хуваарьт өөрчлөлт оруулах болон хилийн Ханх-Монд олон улсын байнгын ажиллагаатай авто замын боомтын амралтын өдрийг Мягмар гарагт шилжүүлэн өөрчлөх санал хүргүүлээ. Боомтын сэргэлтийн үндэсний хорооны 4 дүгээр хуралдааны шийдвэрийг бүсийн газруудад хүргүүлсэн. Дорноговь аймаг дахь газартай хэлэлцэж "Ханги эко логистик" ХХК-ний төслийн хүрээнд шаардлагатай өрөө, тасалгааны тооцоо судалгааг гаргаж, хүргүүлсэн. Ирэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяад Агаарын тээврийг хялбаршуулах болон Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн дэргэдэх нарийн бичгийн даргын ажлын албаны бүрэлдэхүүнд тус тус ажиллах албан тушаалтны мэдээллийг хүргүүлсэн. Монгол Улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийн мэдээллийн нэгдсэн сангаас гадаадын иргэдийн хил	90

1	2	3	4	5	6	7	8
						<p>нэвтрэлтийн мэдээлэлд нэвтрэх эрхийг эрх бүхий албан тушаалтануудад олгуулсан.</p> <p>Зөвлөгөө, мэдээлэл өгдөг call pro 1800-1882 утсаар хариу өгөх үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн төлөөллүүдийг нэмж тушаал боловсруулан батлуулсан.</p> <p>Eviza.mn цахимаар олгож буй визээр Монгол Улсад нэвтрэх гадаадын иргэдийг хилийн боомт дээр буцааж буй тохиолдолд void буюу хүчингүй болгох эрхийг зарим ахлах мэргэжилтэнд нээж, дотоод албан бичгээр чиглэл өгсөн.</p> <p>“Хэлэлцээр, протокол батлах тухай” Засгийн газрын 2024 оны 127 дугаар тогтоолыг боомт орон нутаг дахь газруудад хүргүүлж, албандаа хэрэгжүүлж ажиллах талаар чиглэл өгсөн.</p> <p>Хилийн боомтын захиргаанд хилийн Хавирга-Ар хашаат боомтын шинээр баригдах ачаа тээврийн гарцын холболт, хилийн солбицлын цэгийг тогтоох ажлыг түргэтгэж, боомтын төлөвлөлт болон бүтээн байгуулалтын ажлыг уялдуулах ажлын хэсэгт ажиллах албан тушаалтны мэдээллийг хүргүүлсэн.</p> <p>БНХАУ-ын Хөх хотод ӨМӨЗО-ны Нийгмийг аюулаас хамгаалах газрын хилээр орж гарахын удирдах газартай албаны уулзалт хийж, Өмнөд бүс дэх газрын албаны байрыг засварлах ажлыг шийдвэрлэсэн.</p> <p>Боомтын сэргэлтийн үндэсний хорооны даргад “Монгол, Хятадын хилийн боомтын менежментийн хамтын ажиллагааны комисс”-ын VI хуралдаанд хэлэлцэх саналаа албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Мөн Зорчигч мэдээллийн төвийн “Журам, бүтэц, орон тоо батлах тухай” 174 дүгээр тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байна.</p> <p>Байгууллагын даргын 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/132 дугаартай “Гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн эрх олгох журам”-ыг хүчингүй болгож, нэмэлт өөрчлөлт оруулсан тушаалыг хүргүүлж, хилийн боомтуудад чиглэл өгч ажилласан. Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн хариуцсан Хилийн Цагааннуур авто замын боомтоор “Торгоны зам” Олон улсын авто уралдаанд оролцох тамирчдын нэрсийн жагсаалтыг тулгаж хурдан</p>	

1	2	3	4	5	6	7	8
						<p>шуурхай нэвтрүүлэх талаар чиглэл өгч ажилласан.</p> <p>“Монгол Улсын агаарын хаалгаар нэвтрэн орж ирсэн гадаадын болон Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг онцгой нөхцөл байдлын улмаас хилийн боомтгүй нисэх буудалд аргагүйдсэн буулт үйлдсэн тохиолдолд үйл ажиллагааны зохицуулалт, харилцан ажиллагааг тогтоож хамтран ажиллах журам”-ын төсөлд саналаа тусган хүргүүлсэн.</p> <p>Хилийн Замын-Үүд боомтыг 24 цагийн горимд шилжүүлснээр нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн динамик загвар боловсруулах ажлын даалгаварт саналаа тусгаж, хилийн боомтын захиргааны даргад албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>“Чингис хаан” Олон Улсын нисэх буудлын “Хэрэглэгчдэд үйлчлэх хороо”-ны 2024 оны 3 дугаар хурлын тэмдэглэлийг Агаарын замын боомт хариуцсан газарт хүргүүлж, чиглэл өгсөн.</p> <p>“Хууль бусаар байгаа иргэдийг буцаан шилжүүлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт өөрчлөл болон олон нийтийн сүлжээний талаар, ИНЕГ-аас ирүүлсэн “Монгол Улсын агаарын хилийн нэвтрэх цэгээр орж ирсэн гадаадын болон Монгол улсад бүртгэлтэй агаарын хөлөг хилийн боомтоор тогтоогдоогүй нисэх буудалд аргагүйдсэн буулт үйлдсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний журам”-ыг хилийн боомт, орон нутаг дахь газруудад 10 дугаар сарын 17-ны өдөр цахимаар тус тус чиглэл хүргүүлсэн.</p> <p>Мөн</p> <p>5</p> <p>2024 оны 2 дугаар сараас олож эхэлсэн тухай Монгол Улсын “Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенци”-д нэгдэн ороогүй тул дээрх бичиг баримтаар Монгол Улсын хилээр орох, гарах чиглэлд зорчих боломжгүйг мэдэгдсэн албан бичгийг хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдэд 10 дугаар сарын 28-ны өдөр цахимаар хүргүүлж, чиглэл өгсөн.</p> <p>БНХАУ-тай хиллэдэг хилийн боомт хариуцсан боомт, орон нутаг дахь нэгжүүдээс өдөр дундажаар болон ачаалалтай үед зорчдог БНХАУ-ын иргэдийн тоон судалгааг авч,</p>	

1	2	3	4	5	6	7	8
						<p>танилцуулга хийсэн. Боомтын сэргэлтийн үндэсний хорооны ажлын албаны даргад Өмнөд бүс дэх газар болон хилийн Гашуунсухайт боомтод ажилладаг албан хаагч, 2025 онд тусгасан төсвийн талаар 11 дүгээр сарын 18-ны өдрийн 01/2274 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. Хилийн боомтод гарч буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор цахимаар оршин суух зөвшөөрөл хасалт хийлгэсэн мэдээллийг хил хамгаалах байгууллагын албан хаагч нарт хүргүүлж байх талаар хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн дарга нь чиглэл өгсөн.</p>	
9	<p>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг хангах</p>	<p>Урсгал зардал</p>	<p>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь</p>	97.1	100	<p>Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)-ийг хэрэгжүүлэх 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Гадаадын иргэн, харьяатын газраас авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус баталж, цахим хуудсанд нээлттэй байршуулав.</p> <p>Тайлант хугацаанд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар нийт 74 албан хаагч, иргэний баримт бичгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, дүгнэлтийг үндэслэн тухайн албан тушаалд томилох шийдвэрийг гаргасан.</p> <p>"Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн систем"-д үүсгэсэн мэдүүлэг гаргагч нийт албан тушаалтнуудын 2023 оны мэдүүлгийг хуулийн хугацаанд шинэчлэн гаргуулж, ХАСХОМ-ийн 2023 оны тайлан, ХАС-ын хураангуй, ХОМ-ын хураангуй тайланг цахимаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлэв.</p> <p>Авлигатай тэмцэх газраас авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэрэгтэй тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх, иргэд, олон нийтийн авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор эрхлэн гаргадаг "Шударга ёс" сэтгүүлд Дорноговь аймаг дахь газрын ахлах мэргэжилтэн "Авлигын мөн</p>	90

1	2	3	4	5	6	7	8
						<p>чанар, хор уршиг, Монголчуудын авлигатай тэмцсэн түүхэн уламжлал" сэдэвт илтгэлийг хүргүүлсэн.</p> <p>Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдлын 2023 оны тайланг төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем (ERP)-д нээлттэй байршуулж, албан хаагчдад танилцууллаа.</p> <p>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 11 дүгээр сарын 21-ний өдөр ХШҮАХ-т хүргүүлж, гүйцэтгэлийг 92 хувьтай үнэлсэн.</p>	
10	<p>Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг хангах</p>	Урсгал зардал	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	91.8	100	<p>"Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх Гадаадын иргэн, харьяатын газрын төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2024 оны төлөвлөгөөг салбар зөвлөлийн 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дүгээр хурлаар батлуулсан.</p> <p>Байгууллагын албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг Хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо (ХНУМТ) цахим системд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэг жилийг нэг жил гурван сараар тооцогдохоор нэмэлт хөгжүүлэлт хийлгэх хүсэлтийг 02 дугаар сарын 16-ны өдрийн 01/357 албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.</p> <p>Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний зарим албан тушаалын ангилал, зэрэглэл төрийн тусгай албан тушаалд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, Засгийн газрын 2024 оны 160 дугаар тогтоолын дагуу албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хүрээнд цалин, нэмэгдэл хөлсийг нэмэгдүүлэх дараах арга хэмжээг хэрэгжүүлээ.</p> <p>Төрийн албаны хуулийн 57.2.3, Засгийн газрын "Журам батлах тухай" 160 дугаар тогтоолд заасны дагуу албан хаагчид цол олгох, хураах, хэрэглэх, мэргэшлийн зэрэг, түүний нэмэгдэл олгох журмыг шинээр боловсруулж, байгууллагын даргын А/159, А/241 дүгээр тушаалаар тус тус баталж, албан тушаалын үндсэн цалин 201, зэрэг дэвийн нэмэгдэл 42, цолны нэмэгдэл 198, мэргэшлийн зэргийн нэмэгдэл 178 албан хаагчийн нэмэгдэл хөлсийг</p>	90

1	2	3	4	5	6	7	8
						<p>шинээр болон шинэчлэн тогтоосон. Хууль тогтоомж, санхүүгийн эх үүсвэрт нийцүүлэн байгууллагын даргын 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/154 дүгээр тушаалаар хоолны нөхөх төлбөрийг 34,000, унааны нөхөх төлбөрийг 1,000 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож, 04 дүгээр сарын 01-ний өдрөөс олгож эхэлснээр цалин, хөлсний орлого дунджаар 400,000 төгрөгөөр нэмэгдлээ. Төлөвлөгөөний хүрээнд Төрийн тусгай албан хаагчийн нэгдсэн эмнэлгийн 11 төрлийн эрүүл мэндийн шинжилгээ, эмчийн үзлэгт төв байгууллагын 21 албан хаагчийг хамруулав.</p> <p>"Хөдөлмөрийн дотоод журам"-ын дагуу гэр бүлийн гишүүн нь нас барсан 2 албан хаагчид 1,320,000, өвчний улмаас нас барсан 1 албан хаагчийн гэр бүлд 3,000,000, байгууллагын 1 ахмад настанд 3,000,000 төгрөгийн буцалтгүй тусламжийг байгууллагын даргын 02 дугаар сарын 20-ны өдрийн Б/57, 05 дугаар сарын 28-ны өдрийн Б/134, 08 дугаар сарын 27-ны өдрийн Б/204, 09 дүгээр сарын 20-ны өдрийн Б/252 дугаар тушаалаар тус тус олгосон.</p>	
11	Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай төсөл боловсруулан эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх	Урсгал зардал	Төсөл боловсруулан хүргүүлсэн эсэх	-	1	<p>2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар албан хаагчид нь төрийн тусгай албан хаагчийн ангилалд багтсан. Хуулийн 41.14, 41.18-д "Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэл, албан хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цолны, мэргэшлийн, эрдмийн зэргийн нэмэгдэл олгох журам, нэмэгдлийн хэмжээг Засгийн газраас тогтооно" гэж заасны дагуу Төрийн албаны хууль тогтоомжид нийцүүлэн Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн "Журам батлах тухай" 160 дугаар тогтоолоор байгууллагын албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг шинээр баталсан. Гадаадын иргэн, харьяатын газрын орон тоонд өөрчлөлт оруулах саналыг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлснээр Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн</p>	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/129 дүгээр тушаал батлагдсан. Мөн байгууллагын даргын Гадаадын иргэн, харьяатын газрын төвийн зохион байгуулалтын нэгжүүдийн ажил, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай А/157, Гадаадын иргэн, харьяатын газрын хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай А/158 дугаар тушаалыг тус тус баталлаа.</p>	
12	Албан тушаалын сул орон тоо нөхөх ажлыг зохион байгуулах	Урсгал зардал	Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	<p>Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд 2024 оны 3 дугаар улирлын байдлаар салбар зөвлөлийн 01, 06, 11, 16 дугаар тогтоолоор байгуулсан сонгон шалгаруулалт зохион байгуулах тусгай шалгалтын комисс байгуулж, төрийн захиргааны удирдах 8, гүйцэтгэх 12 албан тушаалын сул орон тоо нөхөх 3 удаагийн тусгай шалгалтыг зохион байгууллаа.</p> <p>“Төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах зар”-ыг нээлттэй байршуулж, нөхөгдөөгүй сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газарт албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Дээрх зарын дагуу 7 иргэн shalgalt@immigration.gov.mn цахим хаягаар Захиргаа, удирдлагын газарт нийслэлийн Газар, зохион байгуулалтын албанаас төрийн захиргааны дэс түшмэлийн 1, Дорноговь аймаг дахь газарт төрийн тусгай байгууллагын дэс түшмэлийн албан тушаалд адилтгах 1, Баруун бүс дэх газарт Увс аймаг дахь хэлтсээс төрийн жинхэнэ албан хаагч 1, Баян-Өлгий аймаг дахь хэлтэст төрийн тусгай байгууллагын дэс түшмэлийн албан тушаалд адилтгах 1, нийт 4 мэргэжилтний албан тушаалд хүсэлт ирүүлсэн. Үүнээс тухайн албан тушаалын тодорхойлолт болон шаардлага хангасан 3 төрийн жинхэнэ албан хаагчийг Захиргаа, удирдлагын газарт хуулийн мэргэжилтэн, Баруун бүс дэх газарт мэргэжилтэн, Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн мэргэжилтнээр тус тус шилжүүлэн ажиллуулахаар шийдвэрлэсэн бол төрийн тусгай байгууллагад ажиллаж байгаа 1 төрийн жинхэнэ албан хаагчийн хувьд үндсэн байгууллага шилжүүлэх</p>	90

1	2	3	4	5	6	7	8
						<p>зөвшилцөлд хүрээгүй тул хүсэлтийг шийдвэрлээгүй.</p> <p>Мөн Санхүү, хангалт үйлчилгээний газрын дарга 1, Мэдээллийн технологийн болон Зөвлөгөө, мэдээллийн хэлтсийн даргын 2, Дорноговь аймаг дахь, Өмнөд бүс, Зүүн бүс дэх газрын даргын 3, Зүүн бүс дэх газрын Сүхбаатар аймаг дахь хэлтсийн даргын 1, нийт 7 сул орон тооны сонгон шалгаруулалтыг 07 дугаар сарын 30-ны өдөр зохион байгууллаа.</p> <p>Сонгон шалгаруулалтад оролцохоор 10 иргэн, төрийн албан хаагч цахимаар бүртгүүлснээс тухайн албан тушаалын тусгай шаардлагыг хангасан 7 төрийн жинхэнэ албан хаагчийг оролцуулж, холбогдох журмын дагуу 60 ба түүнээс дээш оноогоор 100 хувь тэнцсэн.</p> <p>Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр төрийн үйлчилгээний ангиллаас төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэлд шилжсэн төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн мэдээллийн технологи (ерөнхий инженер, сүлжээний, өгөгдлийн сангийн, программ хангамжийн болон сүлжээний инженер)-ийн, санхүү (ахлах нягтлан бодогч, нягтлан бодогч)-гийн чиг үүрэг хэрэгжүүлдэг төрийн үйлчилгээний 26 ажлын байр ТТ-6-аас ТТ-8 зэрэглэлд шилжсэнтэй холбогдуулан Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу салбар зөвлөлийн 06 дугаар сарын 24-ний өдрийн 05 дугаар албан бичгээр ерөнхий шалгалтын нөөцөд бүртгэлтэй, бусад шаардлагыг хангасан 16 албан тушаалын сонгон шалгаруулалтын захиалгыг хүргүүлсэн.</p> <p>Дээрх захиалгын дагуу Төрийн албаны зөвлөлөөс 08 дугаар сарын 23, 26-ны өдрүүдэд тусгай шалгалтыг зохион байгуулж, 16 албан хаагчаас 15 буюу 93.7 хувь нь тэнцэж, 09 дүгээр сарын 06-ны өдрийн 341, 342, 343 дугаар тогтоолоор нэр дэвшүүлснийг хууль тогтоомжийн хүрээнд 09 дүгээр сарын 16-ны өдрөөс тухайн албан тушаалд нь жинхэлж томилон, цалин, нэмэгдэл хөлсийг олгож байна.</p> <p>Одоогийн байдлаар төрийн тусгай гүйцэтгэх 7 албан тушаалын сул орон нөхөх сонгон шалгаруулалтын захиалгыг салбар зөвлөлийн 11 дүгээр сарын 29-ний өдрийн 10 дугаар албан бичгээр хүргүүлээд байна.</p>	
13	Төрийн жинхэнэ албан	Урсгал	Зохион	100	100	Төрийн албаны тухай хуулийн 36.1, Монгол Улсын	100

1	2	3	4	5	6	7	8
	хаагчийн тангараг өргөх ёслолын үйл ажиллагааг зохион байгуулах	зардал	байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь			<p>Ерөнхийлөгчийн 2024 оны 82 дугаар зарлигаар шинэчлэн баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам"-ын дагуу Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 07 дугаар сарын 01-ний өдрийн 17 дугаар, 11 дүгээр сарын 13-ны өдрийн 38 дугаар тогтоолоор нийт 27 албан хаагчийг тангараг өргүүллээ.</p> <p>Төрийн албаны өдрийг тохиолдуулан 07 дугаар сарын 03-ны өдөр төв байгууллагын Хүндэтгэлийн танхимд, Баруун бүс дэх газарт албан тушаалын тусгай шалгалтад тэнцсэн, төрийн жинхэнэ албан хаагчаар томилогдсон төвийн нэгжийн 3, хилийн боомт, орон нутаг дахь газрын 3, нийт 6 албан хаагч, "Бүгд Найрамдах Улс тунхагласан өдөр"-ийг тохиолдуулан 11 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан арга хэмжээнд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр төрийн үйлчилгээний албан тушаалаас төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэлд шилжиж, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан тусгай шалгалтад тэнцсэн 15, салбар зөвлөлөөс зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалын тусгай шалгалтад тэнцсэн 6, нийт төв болон хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн 21 албан хаагчийг оролцуулж, төв байгууллагад нэгдсэн байдлаар ёслолын ажиллагааг зохион байгуулсан.</p> <p>Тангаргийн ёслол Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 304 дүгээр тогтоолоор баталж, 09 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн "Тангаргийн хуудас"-ны загварын дагуу хэвлүүлсэн хуудсаар анх удаа тангараг өргүүлсэн онцлог арга хэмжээ боллоо.</p>	
14	Хилийн боомт, орон нутаг ажилласан албан хаагчид олгох мөнгөн урамшууллыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэх, мэдээллийн санг шинэчлэх	Улсын төсөв	Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	<p>Төрийн албаны тухай хуулийн 61.1, 61.1.1, 61.1.10, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41.20-д заасны дагуу "Гадаадын иргэн, харьяатын газрын төрийн тусгай албан хаагчид хилийн боомт, орон нутагт ажилласан хугацааны мөнгөн урамшуулал олгох журам"-ын төслийг шинээр боловсруулж, 07 дугаар сарын 18-ны өдрийн 02/49 дотоод албан бичгээр төв болон хилийн боомт, орон нутаг дахь газар, хэлтэст хүргүүлэн Захиргаа, удирдлагын газар, Санхүү, хангалт үйлчилгээний газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс, Агаарын замын боомт хариуцсан</p>	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>газар, Дорноговь аймаг дахь газар, Өмнөд бүс дэх газар, Баруун бүс дэх газар, Хойд бүс дэх газар, Зүүн бүс дэх газар, Баян-Өлгий аймаг дахь хэлтэс зэрэг 10 нэгжээс ирүүлсэн. Журмын төслийг 09 дүгээр сарын 30-ны өдрийн Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар танилцуулга, харьцуулалтыг танилцуулж, байгууллагын даргын 10 дугаар сарын 01-ний өдрийн А/406 дугаар тушаалаар баталсан. Захиргаа, удирдлагын газраас нийт албан хаагчдад журмын танилцуулга, мэдээлэл хүргэх ажлыг 11 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгууллаа.</p> <p>Тайлант хугацаанд хилийн боомт, орон нутагт ажилласан хугацааны мөнгөн урамшууллыг байгууллагын даргын 01 дүгээр сарын 17-ны өдрийн Б/20, Б/21, 02 дугаар сарын 21-ний өдрийн Б/58, 04 дүгээр сарын 26-ны өдрийн Б/102, 05 дугаар сарын 20-ны өдрийн Б/128, Б/129, Б/130, 05 дугаар сарын 24-ний өдрийн Б/133 дугаар тушаалаар хилийн боомт, орон нутгийн нэгжид ажиллаж буй 8 хяналтын улсын байцаагчид 271.0 сая төгрөгийн урамшуулал олгосон. Мөн мөнгөн урамшуулал авсан албан хаагчдын нэгдсэн бүртгэлийг тогтмол хөтөлж, баяжилтыг хийж байна.</p>	
15	Албан хаагчдын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох саналыг холбогдох байгууллагад хүргүүлэх	Улсын төсөв	Санал хүргүүлсэн эсэх	1	1	<p>Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай" журамд заасан төрийн алба хаасан хугацаа, тухайн ангилалд ажилласан жил, 2023 оны ажлын гүйцэтгэлийн үнэлгээг харгалзан зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох шаардлага хангасан албан хаагчдын судалгааг нэгтгэж, ахлах, дэс түшмэлийн зэрэг дэв олгуулах саналыг 02 дугаар сарын 01-ний өдрийн 01/260, тэргүүн түшмэлийн зэрэг дэв олгуулах саналыг 02 дугаар сарын 01-ний өдрийн 02/261 албан бичгээр ХЗДХЯ-д, эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийн саналыг 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/241, 03 дугаар сарын 01-ний өдрийн 01/471 албан бичгээр Монгол Улсын Төрийн албаны зөвлөлд тус тус хүргүүлж, шаардлага хангасан албан хаагчдаас ахлах түшмэлийн гутгаар 2, дөтгөөр 2, дэс түшмэлийн тэргүүн 13, дэд 7, гутгаар 13, дөтгөөр 3, нийт 40, Монгол Улсын Ерөнхий сайдын 04 дүгээр сарын 11-ний өдрийн 51 дүгээр захирамжаар эрхэлсэн түшмэлийн дөтгөөр зэрэг дэвийг 1 албан хаагчид</p>	100

1	2	3	4	5	6	7	8
						шинээр болон ахиулан олгууллаа. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 146 дугаар зарлигаар тэргүүн түшмэлийн гутгаар зэрэг дэвийг ахиулан олголоо.	
16	Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны сургалтын төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг хангах	Урсгал зардал	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	99.3	100	<p>Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх Гадаадын иргэн, харьяатын газрын 2024 оны сургалтын төлөвлөгөөг 01 дүгээр сарын 23-ны өдөр баталсан. Төлөвлөгөөний дагуу Удирдлагын академийн төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг чиглүүлэх сургалтад 5, мэргэшүүлэх сургалтад 5, дунд хугацааны давтан сургалтад 9, ахлах түшмэлийн багц сургалтад 3, эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 2, нийт 24 албан хаагчийг суралцуулсан. Байгууллагаас эрх зүйн шинэтгэлийг таниулан хувь хүний хөгжлийг дэмжих, албан хаагчийн чадавхыг дээшлүүлж, зэрэг хандлагыг нэмэгдүүлэх, байгууллагын соёлыг дээшлүүлэх, ёс зүйг сайжруулах зорилгоор зохион байгуулсан 36 удаагийн сургалт, мэдээллийн арга хэмжээ, 2 удаагийн нэгдсэн сургалт, зөвлөгөөнд давхардсан тоогоор 2100 гаруй албан хаагч, бусад байгууллагаас зохион байгуулсан 10 удаагийн сургалтад 42 албан хаагчийг тус тус хамруулжээ. Түүнчлэн байгууллагын даргын тушаалаар албан хаагчдыг ажлын байранд сургах, чадавхжуулах зорилгоор боомт, орон нутаг дахь нэгжийн 23 албан хаагчийг Виз, зөвшөөрлийн газар, Зөрчил шалган шийдвэрлэх газар, Мэдээллийн технологийн хэлтэс, Зөвлөгөө мэдээллийн хэлтэст дадлагажуулан сургасан бол орон нутгийн албан хаагчдыг чадавхжуулах, ажлын ачааллыг бууруулах зорилгоор төвийн нэгжээс 2 албан хаагчийг Өмнөд бүс дэх газар, Баян-Өлгий аймаг дахь хэлтэст тус тус сэлгэн ажиллуулсан.</p> <p>Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Шинэ Дэли хотод зохион байгуулагдсан "Хүний нөөцийн цахимжуулалт" сэдэвт сургалтад 1, Унгар Улсын Будапешт хотноо зохион байгуулагдсан Гадаад иргэдийн бодлого зохицуулах</p>	90

1	2	3	4	5	6	7	8
						<p>ерөнхий газрын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах сургалтад 3, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Хайдербад хотод зохион байгуулагдсан Англи хэлний мэдлэг дээшлүүлэх сургалтад 1, Америкийн Нэгдсэн Улсын Техас мужийн Эл Пасо хилийн боомтод зохион байгуулагдсан “Монгол Улсын хил сахиулах байгууллагуудын албан хаагчдад зориулсан хилийн аюулгүй байдал, төмөр замын зорчигч, ачаа тээврийг шалгах нь” сургалтад 2, Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотод зохион байгуулагдсан “Монгол Улсын Гадаадын иргэн, харьяатын газрын хүртээмжтэй үйлчилгээ, менежментийн чадавхийг бэхжүүлэх нь (2023-2025)” сургалтад 17 албан хаагч, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын “Бүс ба зам санаачлагын түнш орнуудын угсаатны бодлого ба практикийн семинар” сургалтад 2, Америкийн Нэгдсэн Улсын “Чикагогийн хууль сахиулах эмэгтэй алба хаагчдын холбоо”-ноос зохион байгуулах “Цагдаагийн эмэгтэй алба хаагчдын олон улсын холбооны 61 дэх удаагийн сургалт, хурал”-д 1, Тайванийн Минчуаны их сургуулийн мандарин хэлний сургалтад 2, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын “Боомт, орон нутгийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах” айлчлал, сургалтад 5, Швейцарын Холбооны Улсын Женев хотноо “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 81 дүгээр чуулган”-д 1, Тайванийн Цагаачлалын албаны “Гадаад улс орнуудын цагаачлалын албаны ажилтнуудад зориулсан 2024 оны жишиг сургалт”-д 2, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шанхайн бизнесийн их сургуулиас зохион байгуулсан сургалтад 2, нийт 12 удаагийн гадаад сургалтад 42 албан хаагчийг хамруулсан.</p>	
17	Удирдлагын академийн холбогдох сургалтад албан хаагчдыг үе шаттай хамруулах	Урсгал зардал	Богино, дунд, мэргэшүүлэх багц сургалтад хамрагдалтын хувь	100	100	Удирдлагын академийн Төрийн албаны сургуульд Улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэх сургалт, судалгааны ажлын 2024 оны төлөвлөгөөний дагуу эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 хэлтсийн дарга, ахлах түшмэлийн багц сургалтад 1 хэлтсийн дарга, 1 хяналтын улсын ахлах байцаагч, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх	90

1	2	3	4	5	6	7	8
						дунд хугацааны давтан сургалтад 2, шинээр томилогдсон албан хаагчийн богино хугацааны сургалтад 3 албан хаагчийг тус тус хамруулсан. 2024 оны 09 дүгээр сараас ахлах түшмэлийн багц сургалтад 1, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 7, шинээр томилогдсон албан хаагчийн богино хугацааны сургалтад 2 албан хаагчийг тус тус хамруулж байна.	
18	Удирдах албан тушаалтны цугларалт зохион байгуулах	Урсгал зардал	Зохион байгуулсан арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	-	100	Байгууллагын даргын 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар 01 дүгээр сарын 10-ны өдрөөс 14-ны өдрүүдэд "Удирдах албан тушаалтны нэгдсэн цугларалт"-ыг Улаанбаатар хот, Дорноговь аймаг дахь газарт тус тус зохион байгууллаа. Уг цугларалтад 30 албан хаагч хамрагдсан бөгөөд цугларалтын үр дүнг 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01-02/07 дугаар илтгэх хуудсаар байгууллагын удирдлагад танилцуулсан.	100
19	Жендерийн эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг хангах	Урсгал зардал	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	98.0	100	Жендерийн эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 03 дугаар сарын 29-ний өдөр баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд: - Жендерийн үндэсний хорооноос зохион байгуулсан тэгш оролцоог хангах уриатай "Харилцан хүндэтгэе" аянд нэгдэж, аяны хүрээнд мэдээлэл, постер бэлтгэн 03 дугаар сарын 20-ны өдөр байгууллагын цахим хуудсаар нийт албан хаагчдад хүргэсэн. -"Шинэ үеийн манлайлал" сэдэвт сургалтыг 05 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж, 112 албан хаагчийг цахим болон танхимаар хамрууллаа. -Боомт, орон нутаг дахь нэгжүүд "Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх нь", "Жендерийн эрх тэгш байдал, ажлын байрны бэлгийн дарамт", "Жендерийн тухай ойлголт, Монгол улс дахь Жендерийн эрх тэгш байдал", "Жендэр-эрэгтэйчүүдийн эрүүл мэнд" сэдэвт сургалтад 46 албан хаагчийг тус тус хамруулсан байна. -Төрийн тусгай албан хаагчийн Нэгдсэн эмнэлэг болон орон нутаг дахь нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвд 56 албан хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүл мэндийн шинжилгээнд хамрууллаа. -Виз, зөвшөөрлийн газрын албан хаагчдын хувцас солих өрөөг хүйсийн байдал, онцлог хэрэгцээнд нийцүүлэн засварлаж, 05 дугаар сарын 14-ний өдөр ашиглалтад	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>оруулсан.</p> <p>-Төв байгууллага болон Баруун бүс дэх газрын албан хаагчдын цайны цагаар амрах, хооллох өрөөг стандартын дагуу иж бүрэн тохижуулсан.</p> <p>-Бага насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 1 албан хаагчийг хүүхдээ “Эх нялхас, эрүүл мэндийн үндэсний төв”-д эмчлүүлж, сувилуулах нөхцөл боломжоор хангалаа.</p> <p>Байгууллагын даргын 11 дүгээр сарын 13-ны өдөр баталсан 01-02/60 удирдамжийн дагуу 11 дүгээр сарын 21-ний өдөр Удирдлагын академийн эрх зүйн тэнхимийн ахлах багш С.Ганцэцэгтэй хамтран “Жендэрийн тэгш байдал ба хүний эрх” сэдэвт сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн.</p> <p>Жендэрийн хүчирхийллийн эсрэг 16 хоногийн аянд нэгдэж постер бэлтгэн байгууллагын 1,2 давхарт байршуулж, цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээллэсэн.</p> <p>Төлөвлөгөөний биелэлт 100 хувийн гүйцэтгэлтэй.</p>	
20	<p>Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр “Эцэг, эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийн хангах</p>	Урсгал зардал	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	<p>Эцэг, эхийн зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 01 дүгээр сарын 12-ны өдөр зөвлөлийн даргаар батлуулсан.</p> <p>-Байгууллагаас 6 албан хаагчийн сургуулийн насны 6 хүүхдийг спорт дугуйланд 7 хоногт 3 удаа хамруулсан бөгөөд нэмэлтээр 3 албан хаагчийн 5 хүүхэд хамрагдах хүсэлт ирүүлсэн.</p> <p>-Хан-Уул дүүргийн Спортын хорооноос бага насны хүүхдүүдийн дунд “Уран хөдөлгөөнт гимнастик”-ийн тэмцээн зохион байгуулахтай холбогдуулан байгууллагын дэргэдэх 223 дугаар цэцэрлэгийн хүүхдүүдийг 02 дугаар сарын 28-ны өдрөөс 04 дүгээр сарын 18-ны өдрийг хүртэлх хугацаанд спорт зааланд бэлтгэл хийх нөхцөл боломжоор хангалаа.</p> <p>-“Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сэдэвт сургалтыг 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулж, 79 албан хаагчийг цахимаар болон танхимаар хамруулав.</p> <p>-Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд хүүхдэд шаардлагатай ур чадвар, хүүхдийг өсгөж хүмүүжүүлэхэд анхаарах зүйлс, эцэг, эхчүүдийн нийтлэг гаргадаг алдааны талаарх мэдээлэл агуулсан 2 удаагийн зөвлөмжийг 04 дүгээр сарын 12, 25-ны өдрүүдэд Төрийн</p>	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем (ERP)-д байршуулж, албан хаагчдад хүргэлээ.</p> <p>-Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн тохиолдуулан албан хаагчдын 23 хүүхдийг өдөр төв байгууллагын ажлын байр болон Чингис хаан олон улсын нисэх буудлын ирэгч, явагчийн танхим, агаарын зорчигч тээвэр, Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Эрэлч нохойн сургалтын төвтэй танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>09 дүгээр сарын 24-ний өдөр Нийслэлийн хүүхэд, гэр бүл, хөгжийн хэлтсийн дарга Х.Оюунтуяатай хамтран "Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга" сэдэвт сургалтыг зохион байгуулж, 104 албан хаагчийг цахим, танхим хэлбэрээр хамрууллаа.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Хүүхдийн төлөө дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг 11 дүгээр сарын 15-ны өдрийн 02/2263 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Төлөвлөгөөний биелэлт 100 хувийн гүйцэтгэлтэй.</p>	
21	Албан хаагчдыг шагнуулах ажлыг зохион байгуулах	Урсгал зардал	Төрийн дээд, салбарын, байгууллагын шагналаар шагнуулсан албан хаагчдын тоо	21/40/ 29	10/25/2 9	<p>Баян-Өлгий аймаг дахь хэлтэс, Баруун бүс дэх газрын Увс аймаг дахь хэлтсээс Хууль зүйн албаны Тэргүүний ажилтан хүндэт тэмдэгт 1, ХЗДХЯ-ны Хүндэт жуух бичгээр 3 нийт 4 албан хаагчийн шагналын анкет, тодорхойлолтыг 02 дугаар сарын 16-ны өдрийн 01/354, Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан шагнуулахаар төрийн дээд шагналд 8, Хууль зүйн албаны тэргүүний ажилтан хүндэт тэмдгээр 6, ХЗДХЯ-ны Хүндэт жуух бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн. Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 103 жилийн ойн баярыг тохиолдуулан байгууллагын 15 албан хаагчид шагнал гардуулах ёслолын үйл ажиллагааг 07 дугаар сарын 08-ны өдөр зохион байгууллаа.</p> <p>Бүгд найрамдах Улс тунхагласан өдрийг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа идэвх, зүтгэл гарган ажилласан төв, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн 5 албан хаагчийг "Хууль зүйн албаны тэргүүний ажилтан" цол тэмдэг, 5 албан хаагчийг ХЗДХЯ-ны "Хүндэт жуух бичиг"-т нэр</p>	70

1	2	3	4	5	6	7	8
						дэвшүүлж ГИХГ-ын газрын 11 дүгээр сарын 04-ний өдрийн 01/2172 дугаар албан бичгээр хүргүүлж, шагналыг хүлээн аваад байна. Мөн санхүү, эдийн засагчдын өдрийг тохиолдуулан 3 албан хаагчийг Сангийн яамны "Санхүү, банкны тэргүүний ажилтан" хүндэт тэмдэг, 1 албан хаагчийг СЯ-ны "Жуух бичиг"-ээр шагнуулахаар нэр дэвшүүлж 11 дүгээр сарын 25-ны өдрийн 01/2335 дугаар албан бичгээр ХЗДХЯ-д хүргүүлсэн.	
22	Байгууллагын үйл ажиллагаа, эрхлэх чиг үүрэгтэй холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх	Урсгал зардал	Байгууллагын цахим хуудас, олон нийтийн цахим сүлжээнд байршуулсан мэдээлэл, сурталчилсан тоо	228/17 6/489	150/120 /300	Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 72 мэдээ бэлтгэж, байгууллагын цахим сайтад нийт 155 мэдээ, ярилцлага, видео, нээлттэй мэдээлэл зэргийг байршуулж, олон нийтэд ил тод мэдээллээ. Мөн нийгмийн сүлжээ дэх байгууллагын цахим хуудаст нийт 175 мэдээлэл байршуулав. Цахим хуудаст тогтмол мэдээлэл байршуулснаар байгууллагын цахим хуудас 23,933 дагагчтай, дундаж хандалт 20 мянга байна. Бэлтгэсэн мэдээллийг давхардсан тоогоор 467 хэвлэл мэдээллийн хэрэгслээр (380 сайт, 36 сонин, 51 телевиз) сурталчилсан. Тухайлбал, "Гадаадын иргэний оршин суух үнэмлэхийг зөвхөн чингэлтэй дүүргийн нэг цэгийн үйлчилгээний төвд олгоно" гарчигтай мэдээг 31 сайт, 5 телевиз, 3 сонинд, "Хууль бусаар орогнон, эрэн сурвалжлагдаж байсан гадаадын иргэнийг илрүүлэн албадан гаргалаа" мэдээг 19 сайт, 3 телевиз, 5 сонинд, "Өнгөрөгч онд 519 хяналт шалгалтыг зохион байгууллаа" 12 сайт, 2 телевизээр, "2023 онд цахим виз олголт 4 дахин өсжээ" мэдээг 18 сайтад, "Гадаадын иргэн, харьяатын газар бүх ангиллын визийг цахимаар олгож эхэллээ" мэдээг 27 сайт, 5 телевиз, 4 сонинд, "Аялал жуулчлалын визтэй ирээд, хөдөлмөр эрхэлж байсан гадаадын иргэдийг албадан гаргажээ" мэдээ 14 сайт, 2 телевиз, "Аяллын зорилгоо тодорхойлж чадаагүй 22 улсын 593 гадаадын иргэнийг хил нэвтрүүлэлгүй буцаалаа" мэдээг 4 телевиз, 11 сайтад, "АНУ-ын иргэн, гэр бүлд үрчлүүлсэн хүүхдүүдтэй уулзлаа" гарчигтай мэдээг 16 сайт, 2 телевизээр, "Монгол Улсад эрэн сурвалжлагдаж байсан гадаадыг иргэнийг баривчилж албадан гаргалаа" мэдээг 26 сайт, 3 телевиз, 2 сонинд тус тус нийтлүүлсэн байна. 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн байгууллагын	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>арга хэмжээнд Eagle, UBS телевиз, Zuv.mn сайтуудыг оролцуулж мэдээлэл бэлтгүүлсэн. Үүнээс гадна арга хэмжээний мэдээлэл 25 сайтад, байгууллагын дарга болон ХЗДХ-ийн сайдын видео яриаг 6 сайтаар мэдээлсэн.</p> <p>2024 оны есдүгээр сарын 19-ний өдөр Ийгл телевизийн "Зочны цаг" ярилцлагын нэвтрүүлгээр Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр гадаадын иргэний хяналт, виз, оршин суух зөвшөөрөл, холбоотой асуудлаар мэдээлэл өгсөн.</p> <p>2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран зохион байгуулсан "Монгол Улсын цагаачлалын салбарын цахим шилжилт" уулзалт, арга хэмжээг Ийгл телевиз, NTB телевиз, UBS телевиз, Цахиур.мн сайт, МРА мэдээллийн агентлагууд сурвалжлав. Мөн арга хэмжээний мэдээг 18 мэдээллийн сайтад түгээсэн.</p>	
23	Нээлттэй мэдээллийг ил тод нийтлэх	Урсгал зардал	Нээлттэй мэдээлэл байршуулалтын хувь	94	100	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, байгууллагын даргын 2022 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн "Нээлттэй мэдээллийг нийтэд ил тод мэдээлэх ажлын зохион байгуулалтын тухай" А/135 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж, байгууллагын чиг үүрэг, стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж буй үйлчилгээний талаарх 78 төрлийн мэдээллийг нээлттэй мэдээлж байна. Тайлант хугацаанд зохион байгуулалтын нэгжүүдээс ирүүлсэн 99 мэдээллийг нээлттэй байршууллаа. Үүнд:</p> <p>Үйл ажиллагааны чиглэлээр 84</p> <ul style="list-style-type: none"> - Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын мэдээлэл 35 - Статистик тоон мэдээлэл 12 - Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн мэдээлэл 10 - Үйл ажиллагааны тайлан мэдээлэл 25 - Төлөвлөгөө 2 <p>Хүний нөөцийн чиглэлээр 15</p> <ul style="list-style-type: none"> - Сонгон шалгаруулалтын мэдээлэл 7 - Салбар зөвлөлийн мэдээлэл 2 - Тайлан 3 - Сургалтын төлөвлөгөө 1 - Авлигын эсрэг үйл ажиллагаатай холбоотой 2 мэдээллийг тус тус байршууллаа. 	90

1	2	3	4	5	6	7	8
						Shilen.gov.mn цахим хуудаст Гадаадын иргэн, харьяатын газар чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний талаарх мэдээллүүдийг ил тод, нээлттэй байршуулж, 2024 оны хоёрдугаар улирлын нээлттэй мэдээллийн ил байдлын үнэлгээгээр 98 хувьтай үнэлэгдлээ. 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр 4 дүгээр улирлын тайланг гаргаж, shilen.gov.mn системээр илгээв.	
24	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тайлбар өгөх	Урсгал зардал	Холбогдох асуудлаар тайлбар гаргаж ажилласан гүйцэтгэлийн хувь	100	100	2024 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Neguun.mn мэдээллийн цахим хуудаст “Үндэсний цахим аюулгүй байдлын хэмжээнд нөлөөлөхүйц олон тооны буюу 100 мянга гаруй БНХАУ-ын иргэн Монгол Улсад ажиллаж, амьдарч байна” гэх агуулгатай мэдээлэл цацагдсан. Үүнтэй холбогдуулан тайлбар мэдээлэл бэлтгэж, байгууллагын цахим хуудаст байршуулан олон нийтэд залруулга мэдээлэл хүргэсэн. Монгол Улсад хууль бусаар орогнон, эрэн сурвалжлагдаж байсан гадаадын иргэнийг илрүүлэн албадан гаргасантай холбогдуулан 2024 оны нэгдүгээр сарын 18-ны өдөр Eagle, NTV, TV5 телевизэд, Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээний төвд нэгдсэн байдлаар олгох талаар 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдөр Eagle, TV8, UBS телевизүүдэд олон нийттэй харилцах ахлах мэргэжилтэн, жуулчлах зориулалтай цахим вивээр орж ирээд хөдөлмөр эрхлэхгүй байх талаар 2024 оны 05 дугаар сарын 17-ний өдөр Зөрчил шалган шийдвэрлэх газрын хяналтын улсын байцаагч Н. Дуламсүрэн Ийгл телевиз, ТВ8 телевиз, MNC телевизид ярилцлага өгөв. Мөн байгууллагын үйлчилгээтэй холбоотой мэдээллийг хүртээмжтэй хүргэх зорилгоор 2024 оны 04 дүгээр сарын 23-ний өдрөөс эхлэн богино хэмжээний цуврал видео мэдээллийг Виз, зөвшөөрлийн газар, Зөвлөгөө, мэдээллийн хэлтсийн албан хаагчидтай хамтран бэлтгэж байна. Тайлант хугацаанд нийт 5 видео контент бэлтгэж байгууллагын цахим сувгуудаар олон нийтэд мэдээлж байна.	90

1	2	3	4	5	6	7	8
25	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх	Урсгал зардал	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	85.0	100	<p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланг 01 дүгээр сарын 02-ны өдрийн 02/10 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг 01 дүгээр сарын 17-ны өдөр байгууллагын даргаар батлуулан төв, орон нутгийн нэгжүүдэд хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 1/403 дугаар албан бичгээр ирүүлсэн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд оруулах саналыг боловсруулж 02 дугаар сарын 06-ны өдөр 01/278 дугаар албан бичгээр хариуг хүргүүлсэн.</p> <p>Хүн худалдаалахтай тэмцэх урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах саналын төслийг боловсруулж хянуулан 02 дугаар сарын 14-ний өдрийн 02/338 дугаар албан бичгээр хариуг хүргүүлсэн.</p> <p>Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 02 дугаар сарын 28-ны өдрийн 02/18 дугаар дотоод албан бичгээр Зөрчил шалган шийдвэрлэх газрын дарга Х.Бэхбатад хүргүүлэв.</p> <p>Дотоодын цэргийн 05 дугаар ангиас 10 дугаар сарын 31-ний өдрийн 03/1028 дугаартай алба бичгийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай" 86 дугаар тогтоол, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагчийн 01 дүгээр албан даалгаварт тусгагдсан гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх "Ногоон бүс" төслийг эрчимжүүлэх олон талт ажлын хүрээнд Дотоодын цэргийн 05 дугаар ангитай хамтран ажлын хэсэг байгуулах, ажлын хэсэгт орж ажиллах 2 албан хаагчийн холбогдох мэдээллийг 11 дүгээр сарын 06-ний өдөр 05 дугаар ангийн Захирагчийн нэгдүгээр орлогч штабын даргад хариуг хүргүүлсэн.</p> <p>Байгууллагын ажил үйлчилгээнд ашиглагдаж байгаа 12 автомашинд Зам тээврийн осол, зөрчил, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор 10 дугаар сарын 25-наас 11 дүгээр сарын 07-ний хооронд өвлийн засвар</p>	50

1	2	3	4	5	6	7	8
						үйлчилгээ, тос масло сольж техникийн бүрэн бүтэн байдалд Санхүү, хангалт үйлчилгээний газартай хамтарч үзлэг шалгалт хийж ажилласан.	
26	Гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах	Урсгал зардал	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь	100	100	<p>Гамшгаас хамгаалах бэлэн байдлын мэдээ, мэдээлэл солилцохоор нээсэн Хууль зүй дотоод хэргийн яамны харьяа байгууллагуудын Viber группэд 01 дүгээр сарын 25-ны өдөр нэгдэн мэдээлэл солилцон ажиллаж байна.</p> <p>Монгол Улсын Тэрроризмтой тэмцэх зөвлөл, түүний ажлын албанаас 02 дугаар сарын 27-ны өдөр ирүүлсэн "Чиглэл хүргүүлэх" тухай 21/30 дугаар албан бичгийн дагуу Зорчигчийн мэдээллийн төвийн дүн шинжилгээний хэлтсийн дарга , мэдээллийн аюулгүй байдлын хэлтсийн дарга нарыг байгууллагын Захиргаа, удирдлагын газрын дарга /, Мэдээлэл технологийн хэлтсийн дарга -- нартай уулзах уулзалтыг 03 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулсан.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоолоор Улсын хэмжээнд Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан шар усны үерээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах зорилгоор Зөрчил шалган шийдвэрлэх газар, Хангалт үйлчилгээний хэлтсийн алба хаагчид 03 дугаар сарын 09-ний өдөр байгууллагын барилга байшингийн дээвэр дээрх болон ойр орчмын цас, мөсийг цэвэрлэсэн.</p> <p>Болзошгүй гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлын хүрээнд 03 дугаар сарын 28-ны өдрийн 16:00 цагт зарлан мэдээллийн дуут дохиогоор тус байгууллагын 4 газар, 5 хэлтсийн 85 албан хаагч хамрагдаж, "Гамшгаас хамгаалах бэлэн байдлын дадлага, сургалт" зохион явуулсан талаар 03 дугаар сарын 29-ний өдрийн 01/41 дугаар илтгэх хуудсаар байгууллагын даргад танилцуулагдсан.</p> <p>Байгууллагын даргын 10 дугаар сарын 17-ны өдрийн 01-02/54 дүгээр удирдамжийн дагуу 10 дугаар сарын 25-ны өдөр "Байгууллагын хэмжээнд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний судлах, бүртгэх" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 6 жолооч, 1 аж ахуйн менежер, 2 дотоод хяналтын мэргэжилтэн нар</p>	90

1	2	3	4	5	6	7	8
						танхимаар, орон нутаг дахь нэгжээс 95 албан хаагч цахимаар хамрагдсан.	
27	Төлөвлөгөөт төлөвлөгөөт дотоод шалгалтыг байгуулах болон бус хяналт зохион	Урсгал зардал	Гүйцэтгэлийн хувь	100	100	Гадаадын иргэн, харьяатын газрын дотоод хяналт шалгалтын 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг нэгжийн даргаар хянуулан 01 дүгээр сарын 22-ны өдөр байгууллагын даргаар батлуулсан. Тайлант хугацаанд "Гадаадын иргэн, харьяатын газрын дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам"-ын дагуу төлөвлөгөөт бус 29 дотоод хяналт шалгалтыг 31 албан хаагчид холбогдуулан, гүйцэтгэлийн хяналт шалгалтын 3, төлөвлөгөөт хяналт шалгалт 6 удаа хийж, иргэдээс гаргасан 20 өргөдөл, гомдлыг иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаанд явуулж, тухайн зөрчилтэй холбоотой шалгалтын материал, дүгнэлт, санал бүхий илтгэх хуудсыг байгууллагын даргад танилцуусан.	90
28	Цол олгох журмын төслийг боловсруулж, дээд шатны байгууллагад хүргүүлэх	Улсын төсөв	Журмын төсөл хүргүүлсэн эсэх	-	1	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлд 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсантай холбогдуулан байгууллагын даргын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/474 дугаар тушаалаар "Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчид цол олгох журам"-ыг боловсруулж, батлуулах ажлын хэсэг байгуулагдан, ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/159 дүгээр тушаалаар "Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчид албан тушаалын цол олгох, хэрэглэх, хураах журам" батлуулсан.	100
29	Эрх олгосон албан хаагчдад тэмдэг түших эрх олгох, хүчингүй болгох, хураах, бүртгэл хөтлөх ажлыг зохион байгуулах	Урсгал зардал	Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	Байгууллагын даргын 2024 оны Б/35 дугаар тушаалаар 2, Б/48 дугаар тушаалаар 1, Б/49 дугаар тушаалаар 2, Б/70 дугаар тушаалаар 2, Б/76 дугаар тушаалаар 1, Б/84 дугаар тушаалаар 2, Б/113 дугаар тушаалаар 4, Б/125 дугаар тушаалаар 1, Б/131 дугаар тушаалаар 1, Б/169 дугаар тушаалаар 3, Б/276 дугаар тушаалаар 5, Б/280 дугаар тушаалаар 2, Б/288 дугаар тушаалаар 1, Б/318 дугаар тушаалаар 5 нийт 14 удаагийн тушаалаар 32 албан хаагчид ("хяналтын улсын байцаагч"-ийн болон "бүртгэсэн хүртэл") тэмдэг түшүүлэх ажлыг зохион байгуулж, албан	100

1	2	3	4	5	6	7	8
						хаагчаас хүлээн авсан 3, хүлээлгэн өгсөн 12 тэмдгийн бүртгэлийг хөтөлж, бүртгэлд баяжилт хийсэн. Тэмдэг түшүүлэх тушаалын эх хувийг тухайн албан хаагчийн хувийн хэрэгт баяжилт хийлгэхээр хүний нөөцөд, цахим хувийг сүлжээнд эрх нээлгэхээр Мэдээллийн технологийн хэлтэс болон тухайн албан хаагчийн харьяалах нэгжид тус тус хүргүүлэн ажилласан. Зохион байгуулалтын хэрэгжилт 100 хувь.	
30	Даргын дэргэдэх зөвлөл, Мэргэжлийн зөвлөлийн хурлыг зохион байгуулах	Урсгал зардал	Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	Даргын дэргэдэх зөвлөлийн (2023 оны 12 дугаар сарын 14, 19, 21, 2024 оны 02 дугаар сарын 14, 02 дугаар сарын 16, 03 дугаар сарын 04, 05 дугаар сарын 17-ны өдрийн, 09 дүгээр сарын 30, 10 дугаар сарын 29, 11 дүгээр сарын 09, 25, 29) 11 удаагийн, Мэргэжлийн зөвлөлийн (2023 оны 12 дугаар сарын 28, 2024 оны 01 дүгээр сарын 30, 02 дугаар сарын 19, 03 дугаар сарын 26, 05 дугаар сарын 24, 06 дугаар сарын 06, 09 дүгээр сарын 25, 10 дугаар сарын 18, 11 дүгээр сарын 12) 9, удирдлагын шуурхай (05 дугаар сарын 17, 11 дүгээр сарын 14) 2 удаагийн нийт 22 удаагийн хуралдааныг зохион байгуулж, тэмдэглэлийг хөтөлж, баталгаажуулан ажилласан.	90
31	Төрийн болон албаны нууцын албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулах	Урсгал зардал	Гүйцэтгэлийг хангаж ажилласан хувь	100	100	Төрийн болон албаны нууцын албан хэрэг хөтлөлтийг Төрийн болон албаны нууцын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам, Байгууллагын даргын 2022 оны А/131 дугаар тушаалаар баталсан Төрийн болон албаны нууц хамгаалах журмын дагуу эрхлэн зохион байгуулж байна. Тайлант хугацаанд нууцын зэрэглэлтэй ирсэн 41 албан бичгийг хүлээн авч, эрх бүхий албан тушаалтнуудад биечлэн танилцуулсан. Нууцын зэрэглэлтэй явсан 37 албан бичгийг холбогдох байгууллагад биечлэн хүргэж ажилласан.	100
32	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх	Урсгал зардал	Шийдвэрлэлтийн хувь	96.7	100	Тайлант хугацаанд байгууллагын төвд 835 (иргэнээс 3 талархал 648 өргөдөл, 56 гомдол, албан хаагчдаас 128 өргөдөл), боомт, орон нутаг дахь нэгжүүдэд 158 (иргэнээс 87 өргөдөл, 6 гомдол, албан хаагчдаас 65 өргөдөл), нийт 993 өргөдлийг хүлээн авснаас 961 өргөдлийг шийдвэрлэсэн. Үүнээс 18 өргөдөл хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн байна.	100

1	2	3	4	5	6	7	8
						<p>Нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлт өссөн дүнгээр 96.8 хувьтай, 32 өргөдөл хяналтад буюу шийдвэрлэх шатанд байна.</p> <p>Үүнээс Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс манай байгууллагад 62 өргөдөл (3 талархал, 16 өргөдөл, 43 гомдол) шилжүүлснийг хүлээн авч, шийдвэрлэсэн.</p> <p>Өргөдөл, гомдлыг эхний хагас жилийн тайланг 06 дугаар сарын 27-ны өдрийн 02/1323, 3 дугаар улирлын тайланг 10 дугаар сарын 01-ний өдрийн 02/1940 дугаар албан бичгээр болон цахимаар тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p>	
33	Байгууллагын даргын баталсан тушаал шийдвэрийн бүртгэлийг хэрэгжилтийг хангуулах хөтөлж,	Урсгал зардал	Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	<p>Төлөвлөгөөт хугацаанд хүний нөөцийн чиглэлээр 324, виз, зөвшөөрлийн чиглэлээр 43, зерчил шалган шийдвэрлэх чиглэлээр 391, төрийн бус байгууллагын үйл ажиллагааны зөвшөөрөл шинээр олгох, хугацаа сунгах, татан буулгах чиглэлээр 7, санхүүгийн чиглэлээр 23, бусад чиглэлээр 72, нийт 860 тушаалыг хэвлэмэл хуудсанд хэвлэж, бүртгэлийг хөтлөн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.</p> <p>Тайлант хугацаанд 4 албан даалгавар, 40 тогтоолыг хэвлэмэл хуудсанд хэвлэж, бүртгэлийн хөтөлсөн.</p> <p>09 дүгээр сарын 09 өдрийн 02-08/06 дугаар "Хяналт-шинжилгээ хийх тухай" удирдамжийн дагуу үндсэн үйл ажиллагааны чиглэлээр батлагдсан 259 тушаалын хэрэгжилт, биелэлтийг эхний хагас жилийн байдлаар гарган, нэгтгэж Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэст 09 дүгээр сарын 20-ны өдөр хүргүүлсэн.</p>	90
34	Агаарын замын боомт хариуцсан газар, Өмнөд бүс дэх газар, Баруун бүс дэх газрын архивын үйл ажиллагаанд биечлэн мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх	Урсгал зардал	Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	-	100	<p>Дорноговь аймаг дахь газар, Өмнөд бүс, Баруун бүс, Хойд бүс, Баян-Өлгий аймаг дах хэлтсийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг ERP.mn сүлжээгээр хянаж, засварлуулан хариуцсан нэгжийн дарга БНШК-оор батлуулсан.</p> <p>Агаарын замын боомт хариуцсан газрын устгах хэргийн жагсаалтыг хянан засварлаж, БНШК-ын 2024 оны 1 дүгээр хурлаар хэлэлцэн батлуулсан.</p> <p>Агаарын замын боомт хариуцсан газар, Өмнөд бүс, Баруун бүс дэх газрын архив, бичиг хэргийн эрхлэгч нарт танхимын сургалтаар хичээл зааж, сан хөмрөгтэй биечлэн танилцуулж, архивын баримтад данс бүртгэл үйлдэх, тоо бүртгэл хөтлөх талаар мэргэжил-арга зүйгээр хангасан.</p>	90

1	2	3	4	5	6	7	8
						Агаарын замын боомт хариуцсан газрын архив, бичиг хэргийн эрхлэгчийг 2 өдөр данс бүртгэл үйлдэх болон цахим архивын программ дээр дадлага хийлгэв.	
35	2022 оны архивын түр хадгалах хөрөнгө оруулагчийн баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, программд холбох	Урсгал зардал	Программд холбосон хувь	100	100	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/222 дугаар тушаалаар баталсан "Байгууллагын архивын нийтлэг журам"-ын 8 дугаар бүлгийн 8.7, байгууллагын даргын 2023 оны А/65 дугаар тушаалаар баталсан "Цахим баримт бүрдүүлэх, хөтлөх, архивд шилжүүлэх журам"-ын дагуу 2022 оны түр хадгалах хөрөнгө оруулагчийн 111 хадгаламжийн нэгжийн 26954 хуудас баримтыг цахим (PDF) хэлбэрт шилжүүлж и-архив программд холбож дуусгасан.	100
36	Байгууллагын 2023 оны архивыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэх	Урсгал зардал	Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	Байгууллагын архивд "2023 оны баримт хүлээн авах хуваарь"-г ЗУГ-ын даргаар 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр батлуулж, хуваарийн дагуу нэгж, албан хаагчдын 2023 онд хөтөлж, шийдвэрлэсэн цаасан суурьтай 1058 ш хадгаламжийн нэгж, тусгай төрлийн цахим 34 ш баримтыг хүлээн авч, 70 жил хадгалах 909 цаасан суурьтай, задгай баримтаар 19, нийт 1028 хадгалах хадгаламжийн нэгж тус тус бүрдүүлж ангилан байнга хадгалах баримтад данс, түр хадгалах баримтад бүртгэл үйлдсэн. ХЗДХСайдын 2020 оны А/241 дүгээр тушаалаар баталсан "Үндэсний архивын сан хөмрөгийн баримтын улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1-т заасны дагуу "2023 оны архивын баримтын бүрэлдхүүн, тоо, мэдээ"-г нэгтгэн гаргаж, Үндэсний төв архивд 2024 оны 03/14 тоот албан бичиг болон www.arvhives.gov.mn цахим хаягаар хүргүүлэв.	90
37	Байгууллагад ирсэн, байгууллагаас явуулсан албан бичгийн эргэлтийг зохион байгуулах	Урсгал зардал	Зохион байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	Төлөвлөгөөт хугацаанд байгууллагад 3885 албан бичиг ирж, 2519 албан бичгийг явуулсан байна. Хариутай 1184 албан бичгээс 1130 албан бичиг шийдвэрлэгдэж, 54 албан бичиг шийдвэрлэх шатандаа байна. Хариугүй 2701 албан бичиг ирсэн байна. Байгууллагаас гадагш явах 2519 албан бичигт дугаар олгож бүртгэл үйлдэн, холбогдох газарт хаяглан хүргүүлсэн бөгөөд үүнээс 1174 албан бичгийг шуудангийн ажилтанд хүлээлгэн өгч, цахимаар 1126, гарт олгосон 219 албан	90

1	2	3	4	5	6	7	8
						бичиг байна.	
Үнэлгээ: 93.2 хувь							

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин		Хэрэгжилт	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Үнэлгээ (хувь)
				эхний хагас жил	сүүлийн хагас жил				
	1	2	3	4	5		6	7	8
1.	Арга хэмжээ 1. Удирдлагын академиас зохион байгуулсан цахим сургалтад хамрагдах ("Ёс зүй" 1, 2, 3 түвшний сургалт)	сертификатын огноо, дугаар	0	1	2	Төрийн албан хаагчдад зориулан Удирдлагын академиас боловсруулсан "Ёс зүй"-ийн 1, 2, 3-р түвшний цахим сургалтад 02 дугаар 09, 12, 13-ны өдөр хамрагдаж orljenwh6z, ecsjxnp8io, kb8yhvhx1e дугаар "Үнэмлэх" авлаа.	2024.02	2024.02	100
2.	Арга хэмжээ 2. Удирдлагын академиас зохион байгуулсан цахим сургалтад хамрагдах ("Авлигаас ангид төрийн алба" 1, 2, 3 түвшний сургалт)	сертификатын огноо, дугаар	0	1	2	Төрийн албан хаагчдад зориулан Удирдлагын академиас боловсруулсан "Авлигаас ангид төрийн алба"-ны 1, 2, 3-р түвшний цахим сургалтад 02 дугаар 08, 12, 13-ны өдөр хамрагдаж kunasfyqgw, tf4w8d4n4w, uqlmozuczo дугаар "Үнэмлэх" авлаа.	2024.02	2024.02	100
3.	Арга хэмжээ 3. Бусад сургалт	-	0	0	1	Дотоод хэргийн их сургуульд 07 дугаар сарын 04-ний өдөр "Хууль зүйн ухааны доктор"-ын зэрэг хамгаалж, 11 дүгээр сарын 22-ны өдөр БД00087 дугаар диплом авсан.	2024.07	2024.07	-
Үнэлгээ: 100 хувь									

Төлөөлөгөөг үнэлсэн:
ДАРГА
(албан тушаал)


.....
(гарын үсэг)

Төсвийн шууд захирагч
Н.УУГАНБАЯР

Тэмдэг

(огноо)

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА
(албан тушаал)


.....
(гарын үсэг)

Нэгжийн дарга
З.ӨНӨРСАЙХАН/
(огноо)

2024.12.13

Тайлагнасан:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА
(албан тушаал)


.....
(гарын үсэг)

Нэгжийн дарга
И.БААТАРХҮҮ
(огноо)